ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Өвөрхангай аймгийн "Энэрэл Хархорин" ӨЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2025/099/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2025 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosurenp@audit.gov.mn

Аудитор: Р.Цэрэндолгор

Утас: 70323108 Цахим хаяг: Tserendolgorr@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........................................

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа........................................

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........................................

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........................................

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ........................

4. Аудитын тайлан ........................................

4.1 Ерөнхий зүйл ........................................

4.2 Материаллаг байдал ........................................

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........................................

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ............

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................

5. Аудитын илрүүлэлт ........................................

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЗГХЭГ | Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар |
| ХХОАТ | Хувь Хүний Орлогын Албан Татвар |
| ТЕЗ | Төсвийн Ерөнхийлөн захирагч |

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 117
танай ____________-ны №____________-т

ХАРХОРИН СУМЫН “ЭНЭРЭЛ ХАРХОРИН” ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Б.ЦЭРЭНДОЛГОР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Энэрэл Хархорин ӨЭМТ-ийн санхүүгийн тайлангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Энэрэл Хархорин ӨЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар материалын тайланд үндсэн хөрөнгө, бараа материалыг үзүүлэлт тус бүрээр бүрэн гаргаагүй. Бараа материалын тайланд 130,604.1 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй орлогын баримт, шаардах хуудас дутуу, зарлагын баримт хөтлөөгүй, жолоочийн тооцооны хуудсаар тооцоо бодоогүй эд хариуцагчийн тайланд хяналт тавьдаггүй.

Жилийн эцэст 133,575.8 мянган төгрөгийн бараа материалыг тоолж тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллаагүй 71,565.9 мянган төгрөгийн эмийн тендер зарлаагүй байна. Шилэн дансанд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх 3 улирлын мэдээлэл оруулаагүй зөрчил тус тус илэрч Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль, Шилэн дансны тухай хууль, УСНББОУС-ыг мөрдөж ажиллаагүй нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзлээ.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 830.6 сая төгрөгийн санхүүжилт авч 64.6 хувь буюу 537.0 сая төгрөгийг цалингийн зардалд

6225020083

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

зарцуулжээ. Нийт 68.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж бүртгэлд тусгасны 50.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр, 18.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан байна.

**Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 197,417,048.47 | 257,288,222.18 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 14,072,921.78 | 62,984,750.28 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 14,072,921.78 | 62,984,750.28 |
| 3121 | Төгрөг | 14,072,921.78 | 62,984,750.28 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 14,072,921.78 | 62,984,750.28 |
| 33 | АВЛАГА | 72,991,359.60 | 60,727,574.82 |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 1,002,395.00 | 1,517,328.82 |
| 33300 | Татаас санхүүжилтийн авлага | 71,988,964.60 | 59,210,246.00 |
| 33400 | Зээлийн хүүгийн авлага | - | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 110,352,767.09 | 133,575,897.08 |
| 351 | Түүхий эд материал | 92,879,367.09 | 111,715,797.08 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 85,821,202.09 | 88,536,337.08 |
| 35130 | Эм боох материал | 7,058,165.00 | 23,179,460.00 |
| 354 | Хангамжийн материал | 17,473,400.00 | 21,860,100.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,473,400.00 | 21,860,100.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 99,185,443.16 | 136,665,705.81 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | - | - |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 99,185,443.16 | 136,665,705.81 |
| 391 | Газар | - | - |
| 392 | Биет хөрөнгө | 98,127,943.16 | 135,878,205.81 |
| 39201 | Барилга, байгууламж | 11,626,157.81 | 11,626,157.81 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (5,167,181.28) | (6,458,976.60) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 26,750,000.00 | 51,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (20,207,812.50) | (21,689,062.50) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 121,998,137.80 | 164,506,137.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (47,305,112.41) | (72,715,474.96) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,271,486.70 | 16,771,486.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (4,841,086.82) | (7,864,686.94) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,355,105.70 | 1,355,105.70 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,351,751.84) | (1,352,481.20) |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,057,500.00 | 787,500.00 |
| 39301 | Программ хангамж | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 39302 | Хасагдуулаг | (292,500.00) | (562,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | - |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 296,602,491.63 | 393,953,927.99 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 33,065,079.00 | 112,486,749.45 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 33,065,079.00 | 112,486,749.45 |
| 413 | Өглөг | 33,065,079.00 | 112,486,749.45 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 65,079.00 | 16,142,749.45 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 33,000,000.00 | 96,344,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 262,672,281.82 | 280,602,047.73 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 262,672,281.82 | 280,602,047.73 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 36,453,555.00 | 36,453,555.00 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 36,453,555.00 | 36,453,555.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 227,082,459.53 | 245,012,225.44 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 40,956,950.77 | 40,956,950.77 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 186,125,508.76 | 204,055,274.67 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | - | - |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,398.10 | 1,398.10 |
| | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 296,602,491.63 | 393,953,927.99 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 851,624,678.01 | 1,006,151,316.64 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 72,950,681.09 | 116,241,298.64 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 72,950,681.09 | 105,668,566.64 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 95,000.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 95,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 10,339,979.00 | 50,927,100.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 62,515,702.09 | 54,741,466.64 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 10,572,732.00 |
| 123004 | Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэн шилжүүлэг | - | 10,572,732.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 778,673,996.92 | 889,910,018.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс | 778,673,996.92 | 889,910,018.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас | 139,482,164.60 | 889,910,018.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 639,191,832.32 | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 740,233,715.97 | 988,221,550.73 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 740,233,715.97 | 988,221,550.73 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 735,423,715.97 | 978,811,550.73 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 407,373,965.04 | 550,781,806.00 |
| 210101 | Цалин | 407,373,965.04 | 550,781,806.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49,707,156.00 | 64,397,910.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 34,688,014.00 | 44,711,280.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 4,050,630.00 | 5,473,429.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 3,240,505.00 | 4,106,659.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 686,800.00 | 987,353.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 7,041,207.00 | 9,119,189.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 9,666,709.00 | 10,406,479.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 7,674,949.00 | 8,580,699.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,991,760.00 | 1,825,780.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,170,150.00 | 14,821,989.26 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 5,933,000.00 | 2,426,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 8,587,553.00 | 8,078,682.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 1,309,197.00 | 582,557.26 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 929,400.00 | 47,500.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 2,411,000.00 | 2,668,950.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 1,017,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 41,526,273.50 | 109,629,947.65 |
| 210501 | Эм | 41,526,273.50 | 109,629,947.65 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,080,910.00 | 3,655,450.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 2,080,910.00 | 3,655,450.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,112,800.00 | 15,291,070.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 7,112,800.00 | 15,291,070.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 6,851,513.00 | 10,181,539.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,039,700.00 | 5,008,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 432,000.00 | 972,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 577,500.00 | 99,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 35,722.00 | 151,582.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 22,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 2,618,090.00 | 3,368,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 214,856.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 148,501.00 | 345,401.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 191,934,239.43 | 199,645,359.35 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 162,768,500.00 | 162,000,000.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 5,687,235.00 | 6,167,622.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,478,504.43 | 31,477,737.35 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,810,000.00 | 9,410,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,810,000.00 | 9,410,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 9,410,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 4,810,000.00 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 111,390,962.04 | 17,929,765.91 |
| | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 111,390,962.04 | 17,929,765.91 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 706,780,032.32 | 913,261,468.60 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 95,000.00 | 10,572,732.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 95,000.00 | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 95,000.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 95,000.00 | - |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 10,572,732.00 |
| 123004 | Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг | - | 10,572,732.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 706,685,032.32 | 902,688,736.60 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 706,685,032.32 | 902,688,736.60 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 67,493,200.00 | 902,688,736.60 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжих | 639,191,832.32 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 677,049,375.38 | 846,318,740.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 677,049,375.38 | 846,318,740.10 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 672,239,375.38 | 836,908,740.10 |

| | | | |
|---|---|---|---|
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 408,507,062.88 | 537,041,018.37 |
| 210101 | Үндсэн цалин | 408,507,062.88 | 537,041,018.37 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49,628,142.00 | 62,575,961.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 49,628,142.00 | 62,575,961.47 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 9,666,709.00 | 10,406,479.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 7,674,949.00 | 8,580,699.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,991,760.00 | 1,825,780.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,816,735.00 | 16,004,239.26 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,815,500.00 | 2,100,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,528,738.00 | 8,078,682.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,309,197.00 | 582,557.26 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,094,900.00 | 1,927,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,828,400.00 | 3,314,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 240,000.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 31,376,768.50 | 75,256,361.00 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 29,078,768.50 | 71,565,911.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,298,000.00 | 3,690,450.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,414,410.00 | 3,500,450.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 380,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | - | 286,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,034,410.00 | 3,214,450.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,112,800.00 | 15,291,070.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,112,800.00 | 15,291,070.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,401,013.00 | 10,665,539.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 3,039,700.00 | 5,008,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 972,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 577,500.00 | 99,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 35,722.00 | 151,582.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,618,090.00 | 3,368,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 214,856.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 148,501.00 | 345,401.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 549,500.00 | 484,000.00 |
| 210815 | Хүүгийн төлбөрт төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 136,315,735.00 | 106,167,622.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 129,528,500.00 | 100,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,787,235.00 | 6,167,622.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,810,000.00 | 9,410,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,810,000.00 | 9,410,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 9,410,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 4,810,000.00 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 29,730,656.94 | 66,942,728.50 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 34,569,720.00 | 18,030,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 34,569,720.00 | 18,030,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 34,569,720.00 | 18,030,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 34,569,720.00 | 18,030,900.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (34,569,720.00) | (18,030,900.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (4,839,063.06) | 48,911,828.50 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 18,911,984.84 | 14,072,921.78 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 14,072,921.78 | 62,984,750.28 |

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 2 | 2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 36,453,555.00 | (863,732.71) | 116,556,628.30 | 152,146,450.59 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 36,453,555.00 | (863,732.71) | 116,556,628.30 | 152,146,450.59 |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 111,390,962.04 | 111,390,962.04 |
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 36,453,555.00 | 1,398.10 | 227,082,459.53 | 263,537,412.63 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 36,453,555.00 | 1,398.10 | 227,082,459.53 | 263,537,412.63 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 36,453,555.00 | 1,398.10 | 227,082,459.53 | 263,537,412.63 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 17,929,765.91 | 17,929,765.91 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 36,453,555.00 | 1,398.10 | 245,012,225.44 | 281,467,178.54 |

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Энэрэл Хархорин ӨЭМТ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д зааснаар " Хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд Усны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил

үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн зарим заалтад өөрчлөлт орсон байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль шинээр батлагдсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитороас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Энэрэл Хархорин ӨЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тус байгууллагад мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 97,351.4 мянган төгрөгөөр *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 14,072.9 | 62,984.8 | 48,911.8 |
| Авлага | 72,991.4 | 60,727.6 | -12,263.8 |
| Бараа материал | 110,352.8 | 133,575.9 | 23,223.1 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **197,417.0** | **257,288.2** | **59,871.2** |
| Үндсэн хөрөнгө | 99,185.4 | 136,665.7 | 37,480.3 |
| Биет бус хөрөнгө | 1,057.5 | 787.5 | -270.0 |
| **Нийт хөрөнгө** | **296,602.5** | **393,953.9** | **97,351.4** |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 33,065.1 | 112,486.7 | 79,421.7 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 36,453.6 | 36,453.6 | 0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1.4 | 1.4 | 0 |
| Хуримтлагдсан ашиг | 227,082.5 | 245,012.2 | 17,929.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **296,602.5** | **393,953.9** | **97,351.4** |

Тайлант оны санхүүгийн тайланд бараа материал 23.2 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материал 42.5 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж, 1.5 сая төгрөгөөр тавилга эд хогшил нэмэгдэж тайлант оны элэгдлийн зардал 110.6 сая төгрөг байна.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нэг иргэнд ногдох тарифаар 808.6 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний санхүүжилт 105.7 сая төгрөгөөр төсөвлөсөн байна.

Тайлант онд 902.7 сая төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлого 10.6 сая төгрөгийн орлого орсон байна.

**3.5.2 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайланд онд 275.5 сая төгрөгийн бараа материалыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Энэрэл Хархорин ӨЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Энэрэл Хархорин ӨЭМТ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг аудитын менежер П.Хорлоосүрэн , тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Энэрэл Хархорин өрхийн эрүүл мэндийн 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардал 988,221.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,882.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 29 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн.

Энэ хуулийн хүрээнд зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.
*Шийдвэрлэсэн нь*:

Шилэн дансанд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх 3 дугаар улирлын мэдээлэл оруулаагүй байсан тул зөвлөмж өгсөн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар зөрчил илрээгүй

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.*

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | | | | | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл зардлыг шалгах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд зөвлөмж-1, албан шаардлага-3 хүргүүллээ. Үүнд

***<u>Залруулсан алдаа:</u>***

Аудитын явцад залруулга хийгдээгүй.

**5.1 Төлбөрийн акт**

Тус байгууллага дээр акт гараагүй.

**5.2 Албан шаардлага**

**Илрүүлэлт-1:**

Бараа материалын тайланд 130,604.1 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй орлогын баримт, шаардах хуудас дутуу, зарлагын баримт хөтлөөгүй, жолоочийн тооцооны хуудсаар тооцоо бодоогүй эд хариуцагчийн тайланд хяналт тавьж ажиллаагүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>**

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт-2:**

Жилийн эцэст 133,575.9 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>**

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт-3:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, 71,565.9 мянган төгрөгийн эмийн тендер зарлаагүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>**

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

**5.3 Зөвлөмж**

Шилэн дансанд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх 3 дугаар улирлын мэдээлэл оруулаагүй байна

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>**

Алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Алдаа гараагүй | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 0 | 0 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материалын тайланд 130,604.1 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй орлогын баримт, шаардах хуудас дутуу, зарлагын баримт хөтлөөгүй, жолоочийн тооцооны хуудсаар тооцоо бодоогүй эд хариуцагчийн тайланд хяналт тавьж ажиллаагүй байна. | 1 | 130,604.1 | | | 1 | 130,604.1 | | | | | | |
| Жилийн эцэст 133,575.9 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 133,575.9 | | | 1 | 133,575.9 | | | | | | |
| **ДҮН** | **2** | **264,180.0** | **0** | **0** | **2** | **264,180.0** | | | | **00** | **0** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Шилэн дансанд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх 3 дугаар улирлын мэдээлэл оруулаагүй байна. | 1 | | | | 1 | |
| **Дүн** | **0** | **0** | **0** | **0** | **0 0** | **0** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, 71,565.9 мянган төгрөгийн эмийн тендер зарлаагүй байна. | 1 | 71,565.9 | 1 | 71,565.9 | 0 0 | 0 |
| **Нийт дүн** | **2** | **71,565.9** | **1** | **71,565.9** | 1 | |

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

6217143681